



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/229

Булган

Нээлттэй хаалганы өдөр
зохион байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/149 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын байгууллагуудын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх зорилгоор салбарын “Нээлттэй хаалганы өдөр”-ийг Булган суманд зохион байгуулсугай.

2. “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Б.Эрдэнэбаатар - АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Ц.Энх-Амгалан - Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Н.Батжаргал - Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга

Т.Баярбат - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Д.Наранбаяр - Булган сумын Засаг дарга


Ч.Оюунтуяа - Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн захирал

С.Оюунбат - ХАА-н Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн захирал

Нарийн бичгийн дарга: М.Батчимэг - АЗДТГ-ын НБХ-ийн ахлах мэргэжилтэн

3. “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулахад мэргэжил арга зүй, удирдлагаар ханган тайлан мэдээг холбогдох дээд байгууллагад хүргүүлэн ажиллахыг ажлын хэсгийн дарга /Б.Эрдэнэбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190248

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 25-өдрийн 229 тоот захирамжийн хавсралт

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЕРӨНХИЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго, үндэслэл

Нээлттэй хаалганы өдөрлөг нь Олон Улсын хөдөлмөрийн байгууллага байгуулагдсаны 100 жил, Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 60 жилийн ойн хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулах, иргэдэд тус салбарын цогц үйлчилгээг үзүүлэхэд оршино.

Хоёр. Өдөрлөгийн хамрах хүрээ, хугацаа

Өдөрлөгийг 2019 оны 04 сарын 30-ны өдрийн 10.00 цагаас Булган сумын ЗДТГ-ын урд талбай, Жаргалант супер маркетын өмнөх талбай, Гэгээ дэлгүүрийн өмнөх гэрэлт гудам зэрэг газруудад тусгай схем зураглалын дагуу зохион байгуулж, Булган сумын 6 багийн иргэдийг хамруулна.

Өдөрлөгийн арга хэмжээг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нэгдсэн удирдлагаар ханган аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар хариуцан ажиллаж, салбарын харьяа бүх байгууллагууд хамтран оролцно.

Гурав. Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл

Өдөрлөгийн хүрээнд дараах үйл ажиллагааг салбарын байгууллагууд хамтран зохион байгуулна. Үүнд:

- Төр засгийн болон аймаг орон нутгийн зүгээс хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэр, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар иргэдэд сурталчлах, зурагт самбар, үзүүлэн таниулах материал бэлтгэн олон нийтэд хүргэх
- Ажлын байрны захиалга бүхий ажил олгогч нарыг оролцуулан ажилгүй иргэдийг ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэх
- Салбарын үйл ажиллагаатай холбоотой иргэдийн санал бодлыг сонсох, зөвлөгөө өгөх, лавлагаа авах, тэдний санал хүсэлтийг шийдвэрлэх
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, хөтөлбөр, төсөл, үйлчилгээ, арга хэмжээний тухай тараах материал, зурагт хуудас, гарын авлага зэргийг бэлтгэн иргэдэд тарааж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцаг, “Нээлттэй утас” зэргийг ажиллуулах
- Өдөрлөгийн үеэр иргэдээс зохион байгуулж байгаа ажлын үнэлгээний судалгаа авах, судалгааны дүнг нэгтгэх
- Өдөрлөгтэй холбогдуулан урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулах

- Зорилтот өрхөд чиглэсэн тодорхой арга хэмжээг зохион байгуулах /түлээ нүүрсээр хангах, ажлын байранд зуучлах, эрүүл мэндийн даатгалд хамруулах, хамгааллын үйлчилгээг үзүүлэх гэх мэт/
- Шаардлагатай зарим арга хэмжээг газар дээр нь шийдвэрлэх

Дөрөв. Тайлан мэдээ гаргах

Холбогдох агентлаг, хэлтсүүд аймгийн хэмжээнд зохион байгуулсан өдөрлөгийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн 2019 оны 05 сарын 05-ны дотор ХНХЯ-д хүргүүлнэ.

Жич: Дараах хэд хэдэн асуудалд анхаарч ажиллах

- Өдөрлөгт оролцож байгаа салбарын байгууллагуудын ажиллагсад ажлын дүрэмт хувцасаар жигдэрч, хариуцсан ажил үүргээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэж оролцох
- Өдөрлөгийн бэлтгэл ажлыг чанартай зохион байгуулж, талбайн байршлын зураг, схем гаргах, иргэдийг хүлээн авч мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэх
- Өдөрлөгийн үеэр цахилгааны гэмтэл, галын аюул зэрэг гарч болзошгүй аливаа сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сахих
- Булган сумын ажилгүй зорилтот өрхийн иргэдийг хамруулах арга хэмжээг авах талаар багийн Засаг дарга нар идэвхи санаачлагатай ажиллах

-----oO-----